

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Дотоод хяналт, шинжилгээний албаны 2023 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан

Дотоод хяналт, шинжилгээний алба нь 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд компанийн газар, хэлтсүүдийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, эрсдэлийг тодорхойлох, бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр албан даалгавар, зөвлөмж өгч, гүйцэтгэх удирдлагыг мэдээллээр ханган, шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

2023 онд Технологийн үйлчилгээний бизнесийн газар, Дамжуулах сүлжээ ашиглалтын газар, Улаанбаатар хотын сүлжээ ашиглалтын газарт, орон нутгийн газруудаас Сэлэнгэ, Дархан-Уул, Дорнод, Сүхбаатар, Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор, Булган, Орхон, Төв, Дорноговь аймгийн газруудын 2022, 2023 оны зорилтот түвшний болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үр дүн, Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж гүйцэтгэсэн.

Үүнд:

1. Улаанбаатар хотын төвийн 3 газар, 12 орон нутгийн газрын 22 сум, 9 РРС, 2 сайт, 1 нэгжид байр талбай, цамхгийн ашиглалт, техникийн бүрэн бүтэн байдал, техникийн ашиглалт үйлчилгээ, ХАБЭА-н нөхцөл байдал, компанийн болон төслийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудтай танилцан, мэргэжил, арга зүйгээр ханган, зөвлөмж, туслалцаа үзүүлэн ажиллалаа.
2. Компанийн 2023 оны Шилэн дансны цахим системийн хөтлөлт, Шилэн дансны тухай хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтэд улирал тутам хяналт хийж, ЗГХЭГ болон ЦХХХЯ-д тайланг хүргүүлж байна.
3. Технологийн үйлчилгээний бизнесийн газар, Улаанбаатар хотын сүлжээ ашиглалтын газарт, орон нутгийн газруудаас Сэлэнгэ, Дархан-Уул, Дорнод, Сүхбаатар, Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор, Булган, Орхон, Төв, Дорноговь аймгийн газруудад зөвлөмж өгч, албан даалгавруудыг хүргүүлэв.
4. 2022 онд хяналт, шинжилгээ үнэлгээ хийгдсэн газруудаас өгөгдсөн албан даалгавар, зөвлөмжийн биелэлтийн тайланг хүлээн авч, биелэлт, үр дүнд хяналт, үнэлгээ хийсэн.

Дотоод хяналт, шинжилгээний алба